



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 613

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5, 6.4, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 2,784,884.02 (хоёр сая долоон зуун наян дөрвөн мянга найман зуун наян дөрвөн төгрөг хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Алимаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

ДОРНОД АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ /ширхэг/	Ашиглалтад орсон огноо	Нэгж балансын үнэ /төгрөг/	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Принтер /Lazerjet1018/	1	2012	163,100.00	163,100.00
2	Компьютер /Hasee/	1	2011	639,999.80	639,999.80
3	Зөөврийн компьютер /Toshiba/C50-i3.2048ram/	1	2015	1,000,000.00	1,000,000.00
4	Ажилтны сандал	2	2014	26342.11	52,684.22
5	Гагнуурын аппарат	1	2003	244500.00	244,500.00
6	Бороожуулагч	1	2008	684600.00	684,600.00
		7			2,784,884.02
	Нийт дүн				(Хоёр сая долоон зуун наян дөрвөн мянга найман зуун наян дөрвөн төгрөг хоёр мөнгө)